

БНСУ-ын сургуулийн өмнөх боловсролын хөгжлийн өнөөгийн чиг хандлага

Б.Мягмар, Д.Хажидмаа

Монгол Улсын Боловсролын Их Сургууль,

Сургуулийн өмнөх боловсролын сургууль, Арга зүйн тэнхим

Хураангуй

Дэлхийн улс орон хойч ирээдүй бага насны хүүхдийг асран хамгаалах, цогцоор хөгжүүлэх асуудлыг нэн тэргүүн тавьдаг бөгөөд энэ нь тухайн улс орны хөгжлийн баталгаа болдог. Олон улсад боловсролын салбарын хөгжлөөр тэргүүлэгчдийн нэг Бүгд Найрамдах Солонгос Улсын сургуулийн өмнөх боловсролын бодлого, хөгжлийн өнөөгийн чиг хандлага, хүртээмжийн талаар судалсан судалгааны зарим үр дүнг танилцуулж байна. БНСУ-ын сургуулийн өмнөх боловсролын бодлого нь олон улсад сургуулийн өмнөх боловсролын өрсөлдөх чадварыг бэхжүүлэх, сургуулийн өмнөх боловсролын инновацийг дэмжих, төсвийн санхүүжилтийг нэмэх, хүүхдэд тэгш хүртээмжтэй олгох боловсролын үйлчилгээг чанаржуулах, бага орлоготой иргэдийн хүүхдийг улсын цэцэрлэгт хамруулах зэрэг бодлогуудыг үе шаттай хэрэгжүүлэн ажиллаж байна. Сургуулийн өмнөх боловсролын хөгжлийн чиг нь үндэсний хэмжээнд мөрдөгдөж буй хөтөлбөрийг Нийгмийн Халамжийн Яамны харьяа ясли-цэцэрлэгүүд хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, хөтөлбөр, стандартад шинэчлэл хийх, сургуулийн өмнөх боловсролын салбарын үнэлгээний системийг боловсронгуй болгох гэсэн чиглэлийн хүрээнд шинэчлэл хийж байна.

Түлхүүр үг

Бодлого, боловсрол, хөтөлбөр, чанар, хүртээмж, цэцэрлэг, хэв шинж

Удиртгал

Дэлхийн улс орон хойч ирээдүй бага насны хүүхдийг асран хамгаалах, цогцоор хөгжүүлэх асуудлыг нэн тэргүүн тавьдаг бөгөөд энэ нь тухайн улс орны хөгжлийн баталгаа болдог. Олон улсад боловсролын салбарын хөгжлөөр тэргүүлэгчдийн нэг Бүгд Найрамдах Солонгос Улсын сургуулийн өмнөх боловсролын бодлого, хөгжлийн өнөөгийн чиг хандлага, хүртээмжийн талаар судалсан судалгааны зарим үр дүнг танилцуулж байна.

БНСУ-ын сургуулийн өмнөх боловсролын бодлого нь олон улсад сургуулийн өмнөх боловсролын өрсөлдөх чадварыг бэхжүүлэх, сургуулийн өмнөх боловсролын инновацийг дэмжих, төсвийн санхүүжилтийг нэмэх, хүүхдэд тэгш хүртээмжтэй олгох боловсролын үйлчилгээг чанаржуулах, бага орлоготой иргэдийн хүүхдийг улсын цэцэрлэгт хамруулах зэрэг бодлогуудыг үе шаттай хэрэгжүүлэн ажиллаж байна. Сургуулийн өмнөх боловсролын хөгжлийн чиг нь үндэсний хэмжээнд мөрдөгдөж буй “Нүри” хөтөлбөрийг Нийгмийн Халамжийн Яамны харьяа ясли-цэцэрлэгүүд хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, 0-2 насны хүүхдийг хөгжүүлэх хөтөлбөр, стандартад шинэчлэл хийх, сургуулийн өмнөх боловсролын салбарын үнэлгээний системийг боловсронгуй

болгох гэсэн чиглэлийн хүрээнд шинэчлэл хийж байна. БНСУ-д Боловсролын яамны харьяа төрийн ба төрийн бус өмчийн цэцэрлэг, Нийгэм Халамжийн Яамны харьяа ясли-цэцэрлэгүүдээр сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээг үзүүлдэг. Цэцэрлэг нь Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн дагуу Боловсролын яаманд харьяалагддаг бол харин ясли-цэцэрлэг нь (асрах үйлчилгээ) Нийгэм Халамжийн Яам болон орон нутгийн засаг захиргааны байгууллагын харьяалалд багтдаг. Боловсролын яамны харьяа цэцэрлэг нь 3-5 насны хүүхдэд, Нийгэм Халамжийн Яамны харьяа ясли-цэцэрлэг нь 0-5 насны хүүхдэд боловсролын үйлчилгээ үзүүлдэг.

БНСУ-ын 2010-2012 оны статистик судалгаагаар сургуулийн өмнөх насны хүүхдийн 80,2 хувь нь сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж байсан бол 2013-2017 оны судалгаагаар 90 хувь болж өссөн байна. Сургуулийн өмнөх боловсролд хамрагдах үр дүн нь хүүхдэд сургалтын зардлын дэмжлэгийг Засгийн газраас үзүүлж байгаатай холбоотой юм. Үүнтэй уялдан төрийн бус өмчийн цэцэрлэг, ясли-цэцэрлэгийн тоо нэмэгдэж, хүртээмж нь ихэссэн байна.

✉ miran@msue.edu.mn

Монгол Улс нь “Хүүхэд бүрийг цэцэрлэгт” зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хүүхдийн цэцэрлэгийн хүчин чадал, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, хүүхэд бүрийг цэцэрлэгт суралцах боломжийг өргөжүүлэх бодлогыг Засгийн Газраас дэвшүүлж буй боловч өнөөгийн хүн амын өсөлт, сургууль цэцэрлэгийн хүртээмж хангалтгүй байгаагаас тус бодлого хэрэгжихэд зарим талаар учир дутагдалтай байна.

Үндсэн хэсэг

БНСУ-ын сургуулийн өмнөх боловсролын бодлого нь олон улсад өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх байдлаар тодорхойлогдож байна. Үүний зэрэгцээ сургуулийн өмнөх насны хүүхдэд тэгш хүртээмжтэй олгох боловсролын үйлчилгээг чанаржуулах зорилгоор одоогийн цэцэрлэг болон бага насны хүүхдийг асрах, халамжийн үйлчилгээг үзүүлэх зорилго бүхий ясли-цэцэрлэгийн тогтолцоог нэгтгэх, үүнийг зохицуулахын тулд Солонгос улсын Засгийн газар 2014 оны 2 дугаар сард Засгийн газрын бодлого зохицуулах ажлын албанд “Бага насны хүүхдийн боловсрол халамжийн асуудлыг нэгтгэх ажлын хэсэг” байгуулагдан ажиллажээ. Ажлын хэсэг нь 2016 оны сүүл хүртэл гурван үе шаттайгаар боловсрол, халамжийг нэгтгэх ажлын төлөвлөгөө боловсруулсан байна. Нэг, хоёрдугаар шатны үйл ажиллагаа нь эрх зүйн орчин бүрдүүлэх ажил төлөвлөгдсөн бол дараагийн шатад харьяа байгууллага болон төсөв санхүүжилттэй холбоотой ажлууд төлөвлөгдөн хийгдэж байна. Дараагийн асуудлуудад багшлах хүний нөөцийг бэлтгэх нь энэ ажлын салшгүй нэг хэсэг болон төлөвлөгджээ. Солонгос улсад дүүрэг, орон нутгаас нь сургуулийн өмнөх боловсролын инноваци бодлогыг дэмжих асуудлыг онцгойлон авч үзэж байна.

Сургуулийн өмнөх боловсролын хөгжлийн чиг хандлага нь дараах асуудлуудад төвлөрч байна. Үүнд: үндэсний хэмжээнд мөрдөгдөж буй “Нүри” хөтөлбөрийг Нийгэм Халамжийн Яамны харьяа асрах газар буюу ясли-цэцэрлэгүүдэд хэрэгжүүлэх, 0-2 насны хүүхдийг хөгжүүлэх хөтөлбөр, стандартыг шинэчлэх, хүүхдийг үнэлэх үнэлгээг илүү боловсронгуй болгох, хүүхдийн тоглох үйл ажиллагаанд тулгуурласан хүүхэд төвт сургалтын зарчмыг баримтлах, хүүхдийг тайван, эрүүл аюулгүй орчинд хөгжиж төлөвшихөд эцэг эх асран хамгаалагчдын оролцоог нэмэгдүүлэх, цэцэрлэг, гэр бүлийн хамтын ажиллагааг дэмжих, эмзэг бүлгийн хүүхдэд үзүүлэх халамж үйлчилгээний чанарт

анхаарах, багшийн хөгжлийг дэмжих зэрэг чиглэлүүдийг чухалчилж байна.

БНСУ-д Боловсролын яамны харьяа төрийн ба төрийн бус өмчийн цэцэрлэг, Нийгэм Халамжийн Яамны харьяа ясли- цэцэрлэгүүдээр сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээг үзүүлдэг.


1. Цэцэрлэг болон бага насны хүүхэд асрах ясли-цэцэрлэгийн ялгаа

Хүснэгт 1

Ангилал	Цэцэрлэг	Бага насны хүүхдийн асрах газар буюу ясли-цэцэрлэг
Хуулийн зохицуулалт	Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль (боловсролын байгууллага)	Бага насны хүүхдийг асран халамжлах тухай хууль (нийгмийн халамжийн байгууллага)
Харьяа байгууллага	Боловсролын Яам (Боловсролын газар)	Нийгэм халамжийн яам /орон нутгийн засаг захиргааны байгууллага/
Насны ангилал	3-5 нас	0-5 нас
Сургалтын хөтөлбөр	Нүри хөтөлбөр	Бие бялдрын хөгжил, асрах сувилах, харилцаа, байгаль судлал, дүрслэх урлаг

2. БНСУ-ын Боловсролын яамны цэцэрлэг болон Нийгэм Халамжийн Яамны харьяа ясли-цэцэрлэгийн эзлэх хувь

Диаграмм 1




Эх сурвалж: БНСУ-ын Боловсролын хөгжлийн хүрээлэн (2017) БНСУ-ын Боловсролын мэдээллийн статистик

БНСУ-ын Нийгэм Халамжийн Яам (2017) БНСУ-ын Нийгэм Халамжийн Яамны статистик мэдээ БНСУ-ын 2017 оны статистик мэдээгээр Боловсролын яамны харьяа цэцэрлэгийн тоо 8.987 буюу нийт сургуулийн өмнөх байгууллагын 18%, Нийгэм Халамжийн Яамны харьяа ясли-цэцэрлэгийн тоо 41.084 буюу сургуулийн өмнөх байгууллагын 82%-ийг эзэлж байна.

3. Боловсролын яамны цэцэрлэг болон Нийгэм Халамжийн Яамны харьяа ясли-цэцэрлэгийн хэв шинж

Диаграмм 2

Эх сурвалж: БНСУ-ын Боловсролын



хөгжлийн хүрээлэн (2017) БНСУ-ын Боловсролын мэдээллийн статистик

БНСУ-ын Нийгэм Халамжийн Яам (2017) БНСУ-ын Нийгэм Халамжийн Яамны статистик мэдээ

Боловсролын Яамны харьяа цэцэрлэг нь улсын-26.3%, хувийн цэцэрлэг -76.4%, Нийгэм Халамжийн Яамны харьяа ясли, хүүхэд асрах төв- улсын-12.1%, хувийн цэцэрлэг-51.6%, сувиллын-6.8%, группийн-3.1%, хүүхэд асрах-22.6%, сайн дурын-0.3%, албан байгууллагын дэргэдэх-3.6% эзэлж байна.

Дээрх хүснэгтээс харахад Боловсролын яамны харьяа цэцэрлэгт хамрагддаг хүүхдийн 3/1% нь улсын цэцэрлэгт, үлдсэн 3/2% нь хувийн цэцэрлэгт хамрагддаг байна.

Нийгэм Халамжийн Яамны харьяа хүүхдийн ясли-цэцэрлэгт байгууллагын дэргэдэх цэцэрлэгүүд харьяалагдан үйл ажиллагаагаа явуулдаг байна. Үүнээс ихэнх буюу 51,6% нь хувийн цэцэрлэгт хамрагдаж, үлдсэн хувь нь байгууллага, группийн дэргэдэх цэцэрлэгт хамрагддаг байна.

4. Сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж байгаа хүүхдийн тооны харьцаа

Хүснэгт 2

Ангилал	2004	2009	2014	2017
Ясли-цэцэрлэг (НХЯ)	800,991	1,175,049	1,406,671	1,451,215
Цэцэрлэг (БЯ)	541,713	537,822	658,188	704,138

Эх сурвалж: БНСУ-ын Боловсролын хөгжлийн хүрээлэн (2017) БНСУ-ын Боловсролын мэдээллийн статистик


БНСУ-ын Нийгэм Халамжийн Яам (2017) БНСУ-ын Нийгэм Халамжийн Яамны статистик мэдээ

Үүнээс харахад сургуулийн өмнөх боловсролын хамрагдалт өсөлттэй харагдаж байгаа боловч Боловсролын яамны харьяа цэцэрлэгийн хамрагдалт харьцангуй бага хувьтай өссөн, харин Нийгэм Халамжийн Яамны харьяа ясли-цэцэрлэгт хамрагдах байдал илүү өсөлттэй байна. Энэ нь бага насны хүүхдийн сургалтын зардлын дэмжлэгийг улсаас нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

5. Сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж байгаа хүүхдийн насны ангилал

Диаграмм 3

Сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж байгаа хүүхдийн насны ангилал



Эх сурвалж: БНСУ-ын Боловсролын хөгжлийн хүрээлэн (2017) БНСУ-ын Боловсролын мэдээллийн статистик

БНСУ-ын Нийгэм Халамжийн Яам (2017) БНСУ-ын Нийгэм Халамжийн Яамны статистик мэдээ, БНСУ-ын Хүн амын статистик мэдээ: 3-5 нас

Дээрх диаграммаас харахад Боловсролын яамны харьяа цэцэрлэгт хүүхэд 3-5 насны хүүхэд суралцдаг ба үүнээс 4-5 насны хүүхдийн эзлэх хувь хамгийн их байгаа нь хүүхдийг сургуульд бэлтгэх сургалтын хөтөлбөр нь сайн явгадгийн нэг үзүүлэлт юм. Харин ясли, хүүхэд асрах төвд балчир насны буюу 0-2 насны хүүхэд ихэнх хувийг эзэлж байгаа нь залуу эцэг эхчүүд амьжиргаагаа дээшлүүлэхийн тулд ажил хийн, хүүхэддээ эдгээр төвөөр асрах үйлчилгээг авдаг байна.

Дүгнэлт

БНСУ-ын сургуулийн өмнөх боловсролын тогтолцоо нь тэгш хамруулах зарчмыг хэрэгжүүлэх боломжийг нээлттэй олгож байгаа ба сургуулийн өмнөх насны хүүхэд бүр сурч боловсрох эрхийнхээ дагуу адил тэгш боломжоор хангагдан, сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдах нөхцөл бүрдсээр байна. Үүний жишээ нь, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын бодлогод бага орлоготой иргэдийн хүүхдийг улсын цэцэрлэгт хамруулах, төлбөрийн дэмжлэг үзүүлэх, төлбөрт уян хатан хандах, хүүхдийг тайван, эрүүл аюулгүй орчинд хөгжиж төлөвшихөд эцэг эх асран хамгаалагчдын оролцоог нэмэгдүүлэх, цэцэрлэг, гэр бүлийн хамтын ажиллагааг дэмжих, 0-2 насны хүүхдийг хөгжүүлэх хөтөлбөр, стандартад шинэчлэл хийх бодлогыг баримтлан ажиллаж байна.

БНСУ-ын сургуулийн өмнөх насны нийт хүүхдийн цэцэрлэгт хамрагдалт 90 хувь болж нэмэгдсэн нь Засгийн газраас сургалтын зардлын дэмжлэгийг үзүүлж байгаатай холбоотой юм. Мөн төрийн бус өмчийн олон хэлбэрийн цэцэрлэгүүдээр сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ үзүүлж байгаа нь сургуулийн өмнөх боловсролын хамрагдалт, хүртээмжийг нэмэгдүүлэхэд чухал хүчин зүйл болж байна. Үүнд: группийн, сайн дурын, сувиллын, хүүхэд асрах, байгууллагын дэргэдэх хэлбэрээр сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ үзүүлж байгаа явдал юм.

БНСУ-д сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний чанар сайжирч, хамрагдалт нь нэмэгдсэн нь сургуулийн өмнөх боловсролыг тогтвортойгоор хөгжүүлэх, эдийн засгийн хувьд бодлогын чанартайгаар дэмжиж байгаа нь нөлөөлж байна.

Манай орны хувьд сургуулийн өмнөх боловсролын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд төрийн бус өмчийн хэлбэрээр сургуулийн өмнөх боловсрол олгох олон хувилбарыг нэмэгдүүлэх, үүнд: байгууллагын дэргэдэх, сайн дурын, сувиллын зэрэг цэцэрлэгүүдийг дэмжин ажиллах шаардлагатай байна. Үүний зэрэгцээ 0-2 насны хүүхдийг асрах, халамжлах үйлчилгээний чиглэлээр ажилладаг байгууллага болох яслийг сэргээн ажиллуулах, ясли-цэцэрлэгийн цогцолборыг дэмжих нь сургуулийн өмнөх боловсролын хүртээмж нэмэгдэхэд нөлөөлөх хүчин зүйл гэж үзэж байна.

Ном зүй

- МУБИС. (2015). Бага боловсролын асуудал, шийдэл. ОУЭШХурлын эмхэтгэл. Улаанбаатар
- МУБИС. (2018). Боловсролын чанар, үр дүн. ОУЭШХурлын эмхэтгэл. Улаанбаатар
- БСШУЯ. (2015). Сургуулийн өмнөх боловсролын сургалтын цөм хөтөлбөр. Улаанбаатар
- МУБИС. (2016). Сургуулийн өмнөх болон бага боловсролын асуудал, шийдэл. ОУЭШХурлын эмхэтгэл
- БНСУ-ын Боловсролын хөгжлийн хүрээлэн. (2017). БНСУ-ын Боловсролын мэдээллийн статистик. <http://kess.kedi.re/index>
- БНСУ-ын Нийгэм Халамжийн Яам. (2017). БНСУ-ын Нийгэм Халамжийн Яамны статистик мэдээ, БНСУ-ын Хүн амын статистик мэдээ:3-5нас. <http://kess.kedi.re/index>
- Korean Educational Statistics Service. From <http://kess.kedi.re/index>
- Lee Eunyoung lecturer (Ph.D) (2018) Gyeongin National University of Education. <https://mecss.gov.mn/page/29/> www.mohw.go.kr <http://kostat.go.kr/portal/eng/index.action> <http://cesi.kedi.re.kr/eng/index>

Current trend of preschool education development in republic of korea

Myagmar.B, Khajidmaa.D
Mongolian National University of Education

Abstract

Every country in the world prioritize the early childhood care for comprehensive development of their younger generation and children which are guarantee for their future development. We have studied current trend, quality, changes and policy of preschool education in Republic of Korea which has one of the leading education sectors in the world. Republic of Korea policy on preschool education aims for improving government policies on preschool education and providing equal access to education for all its citizens. Republic of Korea focuses its reform policies on improving planning, programs, human resource, funding and numbers of public and private kindergartens, supervised by Ministry of Education, kindergartens of Ministry of Social Welfare and Labor and joint researches and parental support. We hereby reveal the results of studies on access to preschool, policies and enrollment between 2004-2017 in South Korea and our analysis on statistical data.

Keywords

Policy, education, program, quality, accessibility, kindergarten
